

ТУЗ-ийн Хурлын Тэмдэглэл

Хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр 15 цаг 30 минутад өөрийн байранд хуралдав.

Оролцсон нь :

1. Н.Соёмбо
2. М.Алтанцэцэг
3. Э.Норовринчин
4. Н.Тулга
5. Х.Анар
6. Ц.Алтансүх
7. М.Адилбиш
8. Т.Батжаргал
9. Б.Нямдэлгэр

Хэлэлцсэн нь :

Компанийн ТУЗ-ийн даргыг сонгох тухай

Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах Үүнд :

1. Цалин урамшууллын хороо
2. Аудитын хороо
3. Стратеги , эрсдлийн хороо

Хурлын явц :

Шинээр сонгогдсон компанийн ТУЗ-ийн гишүүд та бүхэн “Компанийн тухай хуулийн 78.1 дэхь заалт , компанийн дүрмийн 7.4 дэхь заалтыг үндэслэн ТУЗ-ийн даргыг сонгох шаардлагатай . Иймд ТУЗ-ийн даргад компанийн 35544 ширхэг хувьцаа эзэмшигч Н.Соёмбыг нэр дэвшүүлж байна.

2. ТУЗ-ийн дэргэдэх хороод Үүнд :

А. Цалин урамшууллын хороо /Дарга М.Адилбиш , гишүүд М.Алтанцэцэг , Т.Батжаргал /,

Б.Аудитын хороо /Дарга А.Ганцэцэг гишүүд Н.Тулга , Б.Нямдэлгэр /

В. Стратеги эрсдлийн хороо-г /Б.Нямдэлгэр гишүүд Х.Анар ,

Э.Норовринчин / гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах саналтай байна гэж М.Алтанцэцэг танилцуулав.

Санал шүүмжлэл :

Ц.Алтансүх : Нэр дэвшигч Н. Соёмбыг ТУЗ-ын даргаар сонгох саналтай байна. Мөн танилцуулсан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулахад татгалзах зүйлгүй , хороодын дарга гишүүдийг дэмжиж байна. Сайн ажиллаарай гэв.

М.Адилбиш : Тус компанийн нийт хувьцааны 67,6 хувийг эзэмшигч Н.Соёмбыг ТУЗ-ийн даргаар сонгоход татгалзах зүйлгүй . Хуулийн хүрээнд

байгуулагдаж байгаа ТУЗ-ийн дэргэдэх хороод , хороодын дарга гишүүдийг дэмжиж байна гэж хэллээ.

М.Алтанцэцэг : ТУЗ-ийн даргад нэр дэвшигчийг дэмжиж байна. Хууль , дүрэм журмыг баримтлан сайн ажиллах хэрэгтэй гэв. Компанийн тухай хууль болон компанийн дүрмийг баримтлан байгуулагдах хороодыг зүйтэй гэж үзэж байна. Хороодын дарга гишүүдийг зөвшөөрч байна.

Х.Анар : ТУЗ-ийн даргад нэр дэвшигч Н.Соёмбыг дэмжиж байна . Татгалзах зүйлгүй , Хууль дүрэм журмын дагуу компанийн ТУЗ-ийн дэргэдэх Хороодыг байгуулах нь зүйтэй , бүрэлдэхүүнийг нь дэмжиж байна.

Н.Тулга : Дэмжиж байна. Үйл ажиллагаагаа сайн явуулах хэрэгтэй.Мөрдөгдөж буй хууль дүрэм журмын хүрээнд ТУЗ-ийн дэргэд хороод байгуулах шаардлагатай байдаг. Эдгээр хороодыг байгуулахад бүх талаар нь дэмжиж байна гэв.

Т.Батжаргал : Татгалзах зүйлгүй ТУЗ-ийн дарга болон хороодын дарга гишүүдэд нэр дэвшигчдийг дэмжиж байна.

Э.Норовринчин: Уг хурлаар хэлэлцэгдэж байгаа асуудлуудыг дэмжиж байна . Компанийн ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх удирдлага , ТУЗ-ийн дэргэдэх хороод буюу ТУЗ-ийн гишүүдтэй хамтарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна гэснээр санал хураалт явуулав.

Шийдвэрлэсэн нь :

1. ТУЗ-ийн нийт гишүүдийн 100 хувийн саналаар ТУЗ-ийн даргаар Н.Соёмбыг батлахаар,
2. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх

А. Цалин урамшууллын хороо /Дарга М.Адилбиш , гишүүд : М Алтанцэцэг Т.Батжаргал /,

Б.Аудитын хороо /Дарга А.Ганцэцэг гишүүд : Н.Тулга , Б.Нямдэлгэр /

В. Стратеги эрсдлийн хороо-г /Б.Нямдэлгэр гишүүд : Х.Анар ,

Э.Норовринчин / хороодыг байгуулж , дарга гишүүдийг батлахаар, тус тус шийдвэрлэв.

Тэмдэглэл хөтөлсөн  М.Алтанцэцэг

